



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 18 оны 04 сарын 10 өдөр

Дугаар A/18

Баянгол

Тээврийн хэрэгслийн техникийн  
хяналтын үзлэг зохион байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, 21 дүгээр зүйл, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2018 оны А/33 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тээврийн хэрэгслийн хяналтын үзлэгийг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. Авто тээврийн улсын үзлэг 2018 оны 06 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд явагдах тул иргэд, аж ахуйн нэгжид сурталчлах, үзлэгт машин техникийг хугацаанд нь бүрэн хамруулах, бэлтгэл ажлыг хангах сумын нэгдсэн төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Тээврийн хэрэгслийн татвар хураалтыг тогтоосон хувь хэмжээний дагуу хугацаанд нь хурааж төвлөрүүлж дуусгахыг татвар хураагч /С.Тэгшжаргал/-д үүрэг болгосугай.

4. Албан журмын даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг даатгалын төлөөлөгч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

D/Ajil/zahiramj/2018

00700041

Сумын Засаг даргын 20.18 оны 04  
дугаар сарын 10-ны өдрийн А/18  
дугаар захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: М.Тунгалагтамир /Засаг дарга/

Нарийн бичгийн дарга: Х.Төртулга /Засаг даргын орлогч/

Гишүүд: С.Тэгшжаргал /Татвар хураагч/

П.Ууганбаатар /Хэсгийн төлөөлөгч/

Ж.Сайнбилэг /Цагдаа/

Г.Цэнд-Аюуш /Олон нийтийн байцаагч/

Г.Ган-Очир /1 дүгээр багийн Засаг дарга/

Ж.Эрдэнэпүрэв /2 дугаар багийн Засаг дарга/

Ц.Даваадорж /3 дугаар багийн Засаг дарга/

Б.Гантулга /4 дүгээр багийн Засаг дарга/



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/19

Баянгол

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалын “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан нутгийн зөвлөлийн нэгдсэн золголтын арга хэмжээнд 1.000.000 төгрөг, сумд шинээр томилогдон ирсэн хэсгийн төлөөлөгчийн хоол, хүнсний зардалд 300.000 төгрөг, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр шилдэг 8 эмэгтэй шагнахад энгэрийн тэмдгийн үнэ 64.000 төгрөг, сумын төвийн тэнэмэл золбин нохой устгахад 122.000 төгрөг, Булагийн эхийн овоог тахихад 80.000 төгрөг, “Би эстрадын дуучин-2018” улсын уралдаанд оролцох сурагч Г.Тэргэлийн замын зардалд 100.000 төгрөг, төрийн албан хаагчдын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулах зардалд 445.000 төгрөг нийт 2.111.000 төгрөгийг засаг даргын бэлтгэл хөрөнгөнөөс зарцуулахыг төсөв төрийн сангийн мэргэжилтэн /Н.Ганзориг/, нягтлан бодогч /Л.Оюунбилэг/ нарт зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө зарцуулахтай холбоотой санхүүгий анхан шатны баримт материалыг бүрдүүлэн, санхүүтэй тооцоо хийхийг нярав /Б.Уранцэцэг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

D/Ajil/zahiramj/2018

00700042



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 18 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/20

Баянгол

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 71 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох орон тооны бус байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Р.Оюунчимэг /Засаг даргын тамгын газрын дарга/

Нарийн бичгийн дарга: Б.Хорлоожав /Нийгмийн даатгалын байцаагч/

Гишүүд: Х.Даваацэрэн /МЭҮТ-ийн дарга/

Г.Гантулга /Улсын бүртгэгч/

Н.Ганзориг /Төсөв төрийн сангийн мэргэжилтэн/

С.Жагдал /Иргэний төлөөлөл/

Тухайн багийн Засаг дарга

2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг зөвлөлийн дүрмийг баримтлан ажиллахыг даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

D/Ajl/Zahiramj/2018

00700046



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 18 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/21

Баянгол

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаантуг багийн малчин М.Доржсүрэнгийн хоттой малруу галзуугийн шинж тэмдэгтэй үнэг дайрсныг буудан устгаж аймгийн лабораторид тархины дээжийг явуулахад галзуу өвчин оношлогдсон тул Сондуулт багийн Үзүүр худаг орчмын нутагт малын шилжилт хөдөлгөөн, малын гаралтай бүтээгдэхүүн мах, сүү, арьс ширийг гадагш гаргах, борлуулах, мал нядлах, нүүдэл хийхийг бүрэн хориглож, 14 хоногийн хязгаарлалт тогтоосугай.

2. Хязгаарлалт тогтоосон нутаг дэвсгэрийн голомтын мал сүрэгт галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарьж, дүн мэдээг Мал эмнэлэг үржлийн тасагт 2018 оны 04 дүгээр сарын 27-ны дотор ирүүлэх, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зааврын дагуу хийж гүйцэтгэхийг "Тунгалаг Рашаант" ХХК-ийн захирал, малын эмч /Г.Сайнхүү/, Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч /Б.Гантулга/ нарт үүрэг болгосугай.

3. Хязгаарлалтын хугацаанд галзуу өвчний хязгаарлалт тогтоосон бүс нутагт байгаа айлуудын хоточ нохойг байнгын уяатай байлгах, мал шилжүүлэх, малын гаралтай бүтээгдэхүүнийг гадагш гаргахгүй, борлуулахгүй байх ажилд хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга /Ц.Даваадорж/-д даалгасугай.

4. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулж, хяналт тавьж, зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ тооцож, зохион байгуулсан ажлын үр дүн болон хязгаарлалт цуцалсан талаарх тайланг Засаг даргын тамгын газарт ирүүлэхийг Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга /Х.Даваацэрэн/, мэргэжилтэн /Б.Гантулга/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

D/Ajil/Zahiramj/2018

00700048



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 18 оны 04 сарын 17 өдөр

Дугаар A/22

Баянгол

Мэргэжлийн ангийн удирдах  
бүрэлдэхүүн, мэргэжлийн ангийг  
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2018 оны А/79 дүгээр захирамж, Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар байгуулсугай.

2. Мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнийг мэргэжлийн ангийн дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг ханган ажиллуулахыг мэргэжлийн ангийн дарга /Р.Оюунчимэг/-д үүрэг болгосугай.

3. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний сургалт, бэлэн байдлыг хангаж ажиллахыг орлогч бөгөөд сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан /М.Золбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.ТУНГАЛАГТАМИР

D/Ajil/Zahiramj/2018

00700050

Сумын Засаг даргын 20<sup>18</sup> оны <sup>04</sup> дугаар  
сарын <sup>17</sup> -ны өдрийн <sup>182</sup> дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ УДИРДАХ БҮРЭЛДЭХҮҮН

Мэргэжлийн ангийн дарга: Р.Оюунчимэг

Мэргэжлийн ангийн орлогч дарга бөгөөд Сургалт сурталчилгаа хариуцсан  
ажилтан: М.Золбаяр

Холбоо зарлан мэдээлэл хариуцсан ажилтан: О.Зинээзэг

Гамшгаас хамгаалах нөөц хангалт хариуцсан ажилтан: Х.Төртүлга

Аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан ажилтан: Б.Одончимэг

Сумын Засаг даргын 20<sup>18</sup> оны <sup>04</sup> дугаар  
сарын <sup>17</sup> -ны өдрийн <sup>04</sup> дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

**Нэг. Аврах бүлэг /25 хүн/**

1. Б.Гантулга /бүлгийн ахлагч/
2. Э.Тогтбаатар /жолооч/
3. Г.Гантулга /жолооч/
4. Э.Алтайбаатар /аврагч/
5. А.Болдбаатар /аврагч/
6. Д.Ганзориг /аврагч/
7. С.Тэгшжаргал /аврагч/
8. Д.Дандар /аврагч/
9. П.Лхагвабаатар /аврагч/
10. Б.Шинэхүү /аврагч/
11. Д.Алтайбаатар /аврагч/
12. Ц.Батмагнай /аврагч/
13. Г.Батхишиг /аврагч/
14. Н.Ганзориг /аврагч/
15. З.Болд-Эрдэнэ /аврагч/
16. С.Нямдаваа /аврагч/
17. Ш.Нямсүрэн /аврагч/
18. Ч. Тогтохням /аврагч/
19. Л. Хишигбаяр /аврагч/
20. Б.Бямбажав /аврагч/
21. Б.Лхагвадорж /аврагч/
22. Д.Батцагаан /аврагч/
23. Ю.Цогтбаяр /аврагч/
24. Ж.Эрдэнэлүрэн /аврагч/
25. Э.Баярцэнгэл / аврагч /

**Хоёр. Механикжуулсан хэсэг /10 хүн/**

1. Х.Даваацэрэн /хэсгийн ахлагч/
2. Ө.Сугар /гагнуурчин/
3. Ц.Батсайхан /эксковаторчин/
4. Э.Алтанцоож /цахилгаанчин/



5. Х.Гансүх /бульдозерчин/
6. Б.Доржгарав /слесарь/
7. Б.Батбаатар /жолооч/
8. Г.Гаанжуур /компрескорчин/
9. Д.Батбаатар
10. Х.Чонохүү

**Гурав. Эмнэлгийн хэсэг /7 хүн/**

1. Э.Болормаа /хэсгийн ахлагч/
2. Ж.Хишигжаргал /их эмч/
3. Х.Цэенхорол /сувилагч/
4. Х.Төгсбат /жолооч/
5. Д.Нэргүй /асрагч/
6. Д.Дайриймаа /бага эмч/
7. Б.Гэрэлцэцэг /сувилагч/

**Дөрөв. Хэв журам сахиулах хэсэг /8 хүн/**

1. П.Ууганбаатар /хэсгийн ахлагч/
2. Ж.Сайнбилэг /цагдаа/
3. Г.Ган-Очир
4. Г.Болорцэцэг
5. Го.Гантулга
6. Б.Отгончимэг
7. Г.Цэнд-Аюуш
8. Б.Батсоль

**Тав. Сайн дурынхан /15 хүн/**

1. Л.Оюунбилэг /дарга/
2. С.Одмаа /ухуулагч/
3. Ж.Баасан /жолооч/
4. Н.Хандмаа /холбоочин/
5. Б.Нармандах /идэвхтэн/
6. Б.Оюунтүлхүүр /ухуулагч/
7. Д.Эрдэнэтуяа /ухуулагч/
8. Д.Лхагвадулам /ухуулагч/
9. Н.Ариунбаяр /ухуулагч/
10. Г.Дугармаа /ухуулагч/
11. П.Ариунжаргал /ухуулагч/

3.

12. О.Батцэрэн /ухуулагч/
13. Б.Гэрэлт-Од /ухуулагч/
14. Б.Уранцэцэг /ухуулагч/
15. С.Батцэцэг /ухуулагч/



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 17 өдөр

Дугаар АБЗ

Баянгол

Ээлжит цэрэг татлагын ажлыг  
зохион байгуулах тухай

Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2018 оны А/110 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2018 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагын ажлыг дараах бүрэлдэхүүнтэй зохион байгуулсугай.

Дарга: Р.Оюунчимэг /Засаг даргын тамгын газрын дарга/

Гишүүд: С.Цогзолмаа /Эрүүл мэндийн төвийн дарга/

П.Ууганбаатар /Хэсгийн төлөөлөгч/

Г.Ган-Очир /Баянгол багийн Засаг дарга/

Ж.Эрдэнэпүрэв /Хамтын хүч багийн Засаг дарга/

Ц.Даваадорж /Сондуулт багийн Засаг дарга/

Б.Гантулга /Улаантуг багийн Засаг дарга/

2. Цэргийн албанд татагдсан иргэдийг Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолын дагуу эрүүл мэндийн үзлэгт 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 09<sup>00</sup> цагаас сумд оруулахыг Эрүүл мэндийн төвийн дарга /С.Цогзолмаа/-д үүрэг болгосугай.

3. Өмнөх татлагаас эрүүл мэндээр тэнцээгүй иргэдийг эрүүлжүүлсэн, цэрэг татлагын ажлыг зохион байгуулсан тухай илтгэх хуудсыг танилцуулахыг Эрүүл мэндийн төвийн дарга /С.Цогзолмаа/, Засаг даргын тамгын газрын дарга /Р.Оюунчимэг/ нарт даалгасугай.

4. Цэрэг татлагын ажлыг чанартай зохион байгуулахыг Засаг даргын тамгын газрын дарга /Р.Оюунчимэг/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.ТУНГАЛАГТАМИР

D/Ajil/Zahiramj/2018

00700052



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 18 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/24

Баянгол

┌ Сумын хүүхдийн төлөө зөвлөл ┐  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Сумын хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын нэгдсэн төлөвлөгөө гаргаж ажиллахыг зөвлөлийн нарийн бичгийн дарга /Н.Мөнхзул/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

D/Ajl/Zahiramj/2018

00700059

Сумын Засаг даргын 20<sup>18</sup> оны <sup>04</sup>...  
дугаар сарын <sup>18</sup>...-ны өдрийн <sup>17</sup>/<sub>24</sub>  
дугаар захирамжийн хавсралт

### СУМЫН ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга: М.Тунгалагтамир /Сумын Засаг дарга/

Нарийн бичгийн дарга: Н.Мөнхзул /Сургуулийн нийгмийн ажилтан/

Гишүүд: Р.Оюунчимэг /Засаг даргын Тамгын газрын дарга/

М.Золбаяр /Сургуулийн захирал/

Б.Одончимэг /Цэцэрлэгийн эрхлэгч/

С.Цогзолмаа /Эрүүл мэндийн төвийн дарга/

Д.Энхбаяр /Соёлын төвийн эрхлэгч/

П.Ууганбаатар /Хэсгийн төлөөлөгч/

Н.Нарантуяа /Эцэг эхийн төлөөлөл/

Г.Нямбаатар /Сургуулийн өөрөө удирдах зөвлөлийн тэргүүн/

С.Даваахишиг /Хүүхдийн оролцооны байгууллагын төлөөлөл/